



**МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГААНААС  
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛЬ  
ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР 2024 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр

<b>Хэрэгжүүлэх заалт</b>	<b>Хэрэгжилтийн байдал</b>
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль түүнийг дагаж гарсан дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангах, удирдлага, зохион байгуулалт, хариуцлага хяналтын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр:	<ul style="list-style-type: none"><li>➤ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор Далайн захиргааны баталсан журмуудын хэрэгжилтэд байгууллагын ХАБЭА-н орон тооны 2 алба хаагч хяналт тавин ажиллаж байна.</li><li>➤ Далайн захиргаанаас Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой төсөв зардлыг байгууллагын 2024 оны үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөнд тусган батлуулсан.</li><li>➤ Зам, тээврийн салбарын ХАБЭА-н салбар хорооны 2024 оны ажлын төлөвлөгөөтэй уялдуулан Далайн захиргааны ХАБЭА-н орон тооны алба хаагчийн ажлын төлөвлөгөөг баталсан.</li><li>➤ Далайн захиргааны даргын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/110 тоот тушаалаар “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа өгөх журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Усан замын тээврийн хяналтын камер болон аврах завины техникийн ашиглалт хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгаа өгөх журам”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгааны бүртгэлийн маягт”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус журам батлуулсан.</li><li>➤ Далайн захиргааны даргын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/111 тоот тушаалаар “Албан томилолтоор ажиллах журам” түүний удирдамж, зааварчилгааг хавсралтаар батлуулсан.</li></ul>
Байгууллагын үйл ажиллагааны онцлог, ажиллагсдын тооноос хамаарч Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан, бүтэц орон тоог бий болгох чиглэлээр:	<ul style="list-style-type: none"><li>➤ 2024 оны 10 сарын 30-ны өдрийн Далайн захиргааны даргын Б /82 тушаалаар 31 алба хаагчийн бүтэц орон тоо батлагдсантай холбогдуулан ХАБЭА хариуцсан 2 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.</li></ul>

<p>Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн хангалт, чанар, хэрэглээнд шалгалт хийж хяналт тавих, аюулгүй байдлын самбар, санамжуудыг шинэчлэх, шинээр байрлуулах чиглэлээр:</p>	<ul style="list-style-type: none"> <li>➤ Далайн захиргааны зарим ажлын байрны онцлогоос шалтгаалан гүйцэтгэх үүрэгтэй нь уялдуулан усан замын тээврийн бүртгэл, хяналт болон хөлөг онгоцны хяналт, шалгалт хариуцсан мэргэжилтэн, улсын байцаагч нарт зайлшгүй шаардлагатай 8 иж бүрэн хувцас хэрэгслээр хангасан.</li> <li>➤ Мөн Хөвсгөл далай, Архангай өгийн нуур зэрэг амрагчид ихээр цуглардаг газар болон үүдээр орж ирэхэд харагдах газруудад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгсөн 120:180см хэмжээтэй төмөр хөлтэй самбар байрлуулсан болно.</li> </ul>
<p>Ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зохих сургалтад хамруулж, шалгалт авч, "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Сургалтын зохион байгуулалт. Үндсэн дүрэм" MNS 4969:2000 үндэсний стандартын дагуу аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажлын байрны онцлогт тохируулан тогтмол өгч, эрүүл, аюулгүй нөхцөлд ажиллах дадлыг ажилтан бүрт эзэмшүүлсэн байх чиглэлээр</p>	<ul style="list-style-type: none"> <li>➤ “Эрүүл агаар, хөдөлгөөн эрүүл мэнд” уриа дор явган аялал зохион байгуулах /эрүүл ажлын байр хэлэлцүүлэг өрнүүлэх ажлын хүрээнд 2024.04.06-07-ны өдрүүдэд нийт 2 өдрийн арга хэмжээнд байгууллагын албан хаагчид бүрэн хамрагдсан. Эхний өдөр ууланд төлөвлөгөөт алхалт хийж уулын бэлээс орой дээрх цэгт хүрэн, байрлаж байгаа амралт хүртэл 12 км алхаж ирэв. 2 дахь өдөр Бага баян амралтын газарт хамт олноороо сургалтад хамрагдсан.</li> <li>➤ Орон нутагт ажиллаж байгаа албан хаагчдыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар заавар зөвлөмжөөр ханган, байгууллагын 3 албан хаагч орон нутагт ажилладаг бөгөөд ХАБЭА-н заавар, зөвлөгөөг тогтмол хүргэж, хяналт тавин ажиллаж байна. 2024.04.10 болон 2024.04.26-ны өдрүүдэд цахим /zoom/ хурал хийж, эрүүл ахуйн заавар зөвлөгөө өгч ажилласан.</li> <li>➤ Байгууллагын нийт албан хаагчдын дунд спортын уралдаан тэмцээн зохион байгуулах ажлын хүрээнд “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож, эрүүл аюулгүй хөдөлмөр эрхэлцгээе” уриатай 4 дүгээр сарын аяны хүрээнд байгууллагын аварга шалгаруулах тэмцээн 2024.04.27-ны өдөр спортын 5 төрлөөр зохион байгуулагдаж, Захиргаа, удирдлагын хэлтэс шилжин явах цомын эзэн болсон.</li> </ul>
<p>Ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт хамруулах, эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах, байгууллагын эмчийн ажиллах нөхцөл, өрөөний тохижилтыг сайжруулах чиглэлээр:</p>	<ul style="list-style-type: none"> <li>➤ Нийт ажилтан албан хаагчдыг болзошгүй эрсдэлээс хамгаалан Далайн захиргааны даргын 2024 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн А/174 тушаалаар Эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд хамруулав.</li> <li>➤ Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, даван туулах, хамгаалах арга хэмжээг хэрхэн хурдан авах талаар сургалт семинар зохион байгуулах</li> <li>➤</li> </ul>
<p>Хортой нөхцөлд ажиллаж байгаа ажлын байранд хор саармагжуулах бүтээгдэхүүн олгох, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн</p>	<p>Далайн захиргааны ажлын байрууд нь хөдөлмөрийн хэвийн нөхцөлд хамаарагдаж байгаа бөгөөд тайлангийн хугацаанд гарсан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн тохиолдол бүртгэгдээгүй болно.</p>

судалгаа хийж дүгнэлт санал боловсруулж танилцуулах чиглэлээр	
<b>“Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 253 дугаар тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:</b>	
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т заасны дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлыг жил бүр төсөвт тусган зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд хяналт тавих;	<p>ХАБЭА-н хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангахтай холбоотой зардлын төсвийг Далайн захиргааны 2024 оны төсөвт 31 сая төгрөг тусган батлуулсан.</p> <p>Төсөвлөсөн зардлаас 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар дараах ажлуудад хийгдэж, гүйцэтгэлд хяналт тавин ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Согтолтын хэмжээ тандагч драйгер 2ш, согтолтын хэмжээ тогтоогч 1ш, усан замын хяналтын ажилтны хөдөлмөр хамгааллын гутал 5ш нийт 16.800.000 төгрөг зарцуулсан.</li> <li>➤ Ажлын тусгай хувцас Усан замын улсын байцаагчийн өвөл зуны иж бүрэн хувцас хэрэглэлд 9.182.000 төгрөг зарцуулсан.</li> </ul>
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгож, хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгдсэн үзлэг, хяналт, шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ, түүний хэрэгжилтэд хяналт тавьж зөрчил дутагдлыг арилгуулсан байх;	<p>“Байгууллагын хэмжээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван шатны хяналтыг зохион байгуулах журам”-ын дагуу үзлэг, шалгалтыг оффисын болон орон нутаг дахь усан замын тээврийн “Хяналтын пост”-уудад хийж хэвшсэн.</p> <p>Хөвсгөл аймгийн Ханх суман дахь усан замын тээврийн “Хяналтын пост”-ын барилга байгууламжийн ашиглалтын байдалд хийсэн 3-р шатны үзлэг, шалгалтыг 2024 оны 10 дугаар сарын 24-29 -ны өдөр хийсэн. Уг үзлэг шалгалтаар Ханх сумын хяналтын постын байрыг тохижуулах, гэрэлт цамхагтай болох, хаягжилт хийх, постны эргэн тойронд гэрэлтүүлэг хийх зэрэг зөрчил илэрснийг зөрчлийг шуурхай арилгах талаар хариуцсан албан тушаалтан, нэгжийн удирдлагад үүрэг чиглэл болгосон. 2025 оны төсвийн төсөлд тусгасны дагуу ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.</p>

<p>Энэхүү тушаалын 1 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван шатны хяналтыг зохион байгуулах журам"-ыг боловсруулан баталж, хэрэгжилтийг хагас жил тутамд Зам, тээврийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороонд тайлагнаж байхыг харьяа байгууллагын дарга нарт;</p>	<p>Далайн захиргааны даргын тушаалаар Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Ханх сум, Архангай аймгийн Өгий нуур суман дахь усан замын тээврийн "Хяналтын пост"-д 2024 оны 10 дугаар сарын 24-29-ны өдөр 3-р шатны хяналтаар ажилласан мэдээг хүргүүлсэн.</p>
--	--

#### ДАЛАЙН ЗАХИРГАА